



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/45

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Үнэлгээний хорооны 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 62 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төвд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ГААОӨНГ/201812002 дугаартай 3, 22 дугаар багцуудыг "Монос фарм" ХХК, 6 дугаар багцыг "Монфа трейд" ХХК, 7, 17 дугаар багцуудыг "Мөнхийн тун" ХХК, 8 дугаар багцыг "Бүрэн хайрхан сервис" ХХК, 10 дугаар багцыг "Ази фарм" ХХК, 11, 12 дугаар багцуудыг "Айвико" ХХК, 15 дугаар багцыг "Гүн тэнгэрийн нар" ХХК, 16, 20 дугаар багцуудыг "Омбол" ХХК, 18 дугаар багцыг "Оюу дент" ХХК, 24 дүгээр багцыг "Пролианс" ХХК, 27 дугаар багцыг "Монос фарм" ХХК-тай тус тус гэрээ байгуулан, гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар /Ц.Туяа/-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн нийлүүлэхээр санал болгосон барааны тоо, хэмжээ, чанар, нийлүүлэх хугацаа, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Туяа/-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/, Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэбилэг/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНСЭЛЭМ



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

02 00124



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/46

Алтай хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 202 дугаар тогтоолын 3 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/25, А/26 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аварга малчин, аймгийн аварга саальчин, аймгийн аварга тариаланч, аймгийн аварга хадланчийн болзол хангасан хавсралтад заасан малчин, саальчин, тариаланч хадланчдыг шагнасугай.

2. Аймгийн аваргаар шалгарсан малчин, саальчин, тариаланч, хадланчийн шагналд тус бүр 400 мянган төгрөгийг зарцуулсугай.

3. Аймгийн аваргуудын шагнал гардуулахад шаардагдах шатахууны зардалд 3116150 /гурван сая нэг зуун арван зургаан мянга нэг зуун тавин/ төгрөгийг зарцуулсугай.

4. Шагналд зарцуулагдах нийт 39966150 /гучин есөн сая есөн зуун жаран зургаан мянга нэг зуун тавин/ төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /М.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Алтайбаатар/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /П.Баасан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

02 00131

Аймгийн Засаг даргын 2018. оны
 08 дугаар сарын 02 ны өдрийн 146 дугаар
 захирамжийн хавсралт



АЙМГИЙН АВАРГА МАЛЧДЫН НЭРС ДЮА0042

№	Сумын нэр	Багийн нэр	№	Овог	Нэр
1	Алтай	Урт	1	Бадамгарав	Бат-Эрдэнэ
		Бадрал	2	Чойжилсүрэн	Болдбаатар
		Урт	3	Нямаа	Хадбаатар
		Баянцагаан	4	Сарантуяа	Лхагвазаяа
2	Баян-Уул	Хүйсийн говь	5	Хөнхөр	Ууганбаяр
		Баянбогд	6	Ханд	Цогтгэрэл
		Чандмань хайрхан	7	Дэндэв	Мөнх
3	Бигэр	Хүрэмт	8	Өлзийдүүрэн	Баатарчулуун
		Их булаг	9	Норвсамбуу	Амгаланбаатар
4	Бугат	Ферм	10	Янсан	Нямдорж
		Сүж	11	Данаа	Лувсанжамц
		Биж	12	Баатар	Даваа
		Биж	13	Лхачин	Хүрэлсүх
5	Дарив	Ихэс	14	Цагаан	Билэгт
		Жавхлант	15	Даваа	Түвдэндорж
		Хужирт	16	Одхүү	Дамдин
		Жавхлант	17	Ядам	Амарсайхан
6	Дэлгэр	Хужирт	18	Оросоо	Хашбаатар
		Гуулин	19	Борхүү	Амарзаяа
7	Жаргалан	Баян-Өндөр	20	Саарал	Хадбаатар
		Завхан гол	21	Цогтоо	Батсайхан
		Завхан гол	22	Пүрэвээ	Нямзориг
		Завхан гол	23	Бор	Бямбасүрэн
		Бүрэн	24	Лханаасүрэн	Ядамсүрэн
		Бүрэн	25	Даваажав	Чимэдрагчаа
8	Тайшир	Завхан гол	26	Ханджав	Галбаяр
		Галуут	27	Хандсүрэн	Сандагдорж
		Далан	28	Авуу	Батмөнх
		Далан	29	Баасан	Мөнхзаяа
		Галуут	30	Бижгаа	Батбаатар
9	Тонхил	Далан	31	Бат-Өлзий	Алтайбаатар
		Бус-Уул	32	Орос	Баатар
		Тамч	33	Жүгдэр	Баатаржав
		Алтайн оргил	34	Сандаг	Заяахүү
		Зүйл	35	Билгээ	Галбадрах
		Алтансоёмбо	36	Хасаг	Банзрагч
		Тамч	37	Рагчаа	Энхбаатар
10	Төгрөг	Бус-Уул	38	Батжаргал	Бүрэнчедер
		Алтайн оргил	39	Бүтэмж	Бөхбаатар
		Цагаан хайрхан	40	Батцагаан	Баасанжаргал
		Мааньт	41	Равжаа	Ганболд
11	Халиун	Тунгалаг	42	Ванчин	Хадбаатар
		Тунгалаг	43	Ванчиг	Даваамөнх
		Гүү бариач	44	Гэсэр	Оросоо
		Гүү бариач	45	Халтар	Дамдиндорж
		Сүүж	46	Бадарч	Бадрах
		Сүүж	47	Нямдаш	Мянганбуу
12	Хөхморьт	Чацран	48	Энхцэцэг	Бумцэнд
		Гүү бариач	49	Чимэд	Давааням
		Чацран	50	Дорж	Пүрэвжав
		Сангийн далай	51	Аюур	Дандар

		Завхан гол	52	Хүүхэнхүү	Батсүх
		Цоохор нуур	53	Пүрэвдорж	Нанзад
		Цоохор нуур	54	Гончиг	Сүхбаатар
		Завхан гол	55	Гончиг	Нэмэхбаатар
13	Цогт	Төгрөг	56	Халтархүү	Энэбиш
		Баян-Улаан	57	Лхагва	Алтанхундага
		Рашаант	58	Загд	Болдбаатар
14	Цээл	Дэрстэй	59	Жанцхүү	Цогтбаатар
		Баянгол	60	Халзан	Сүхээ
		Бүрэн жаргалан	61	Охин	Батаа
		Жаргалт	62	Санжсүрэн	Зууяа
		Жаргалт	63	Нансал	Даваасүрэн
		Баянгол	64	Буудай	Гантулга
15	Чандмань	Бүрэнжаргалан	65	Түдэвдорж	Төмөрбаатар
		Эрдэнэ-Уул	66	Балт	Хуягбаатар
		Өлзийбулаг	67	Бямбажав	Нямдорж
		Эрдэнэ-Уул	68	Чилхаа	Эрдэнэбат
		Чандмань-Уул	69	Цэрэн	Очирхуяг
16	Шарга	Хүрхрээ	70	Дашжав	Дашдорж
		Баянгол	71	Цогбадрах	Ганболд
		Хамтын хүч	72	Ням	Мөнхжаргал
		Сондуулт	73	Баримсай	Гомбосүрэн
		Улаан туг	74	Нансал	Гомбодорж
17	Эрдэнэ	Баянгол	75	Тогт	Тайван
		Өлзийт	76	Ринадорж	Ганболд
		Цагаан уул	77	Цэдэндамба	Энхболд
		Цагаан уул	78	Гомбо	Бэрэнчомбо
		Цэцэг нуур	79	Бавуудорж	Бяруузана
		Цагаан уул	80	Хумбаан	Батзаяа
18	Есөнбулаг	Баянхайрхан	81	Лхамжав	Гэндэнжамц
		Рашаант	82	Пүрэв	Дагвадорж
		Наран	83	Буянтогтох	Баянтер
		Наран	84	Чулуун	Бадрал
		Рашаант	85	Борхүү	Сүхээ

Аймгийн аварга саальчин

№	Сумын нэр	Багийн нэр	№	Овог	Нэр
1	Тайшир	Галуут	1	Нямбуу	Алтанцэцэг
2	Бигэр	5-р баг	2	Ишигхүү	Тэгшсүрэн

Аймгийн аварга тариаланч

№	Сумын нэр	Багийн нэр	№	Овог	Нэр
1	Тайшир	Хуримт баг	1	Дагва	Болдбаатар
2	Шарга	Баянгол	2	Баянтөгсийн	Бадмаабанзрагч
3	Тонхил	Алтансоёмбо	3	Рэнцэндорж	Болд

Аймгийн аварга хадланч

№	Сумын нэр	Багийн нэр	№	Овог	Нэр
1	Чандмань	Хүрхрээ	1	Хандсүрэн	Төмөрбаатар
2	Шарга	Сондуулт	2	Далжжав	Хадбаасан



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 147

Алтай хот

Улсын нөөцөөс үнэгүй олгох өвс,
50 хувь хямдарсан тэжээлийн хуваарь
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Улсын нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь хэсэг, 16.1.1 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд өвөлжилт хүндэрсний улмаас Улсын нөөцийн салбар, цэгүүдээс сумдад үнэгүй олгох өвс, 50 хувь хямдарсан тэжээлийн тоо хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Улсын нөөцөөс үнэгүй болон хямдарсан үнээр олгосон өвс, тэжээлийг зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчил гаргуулахгүй ажиллахыг Онцгой байдлын газар /Ш.Ган-Эрдэнэ/, Цагдаагийн газар /Г.Түмэннасан/, сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Зарцуулалтын тайланг 2018 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг Онцгой байдлын газар /Ш.Ган-Эрдэнэ/, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /Ш.Ган-Эрдэнэ/, Цагдаагийн газар /Г.Түмэннасан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Б.Баян-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

02 00258

Аймгийн Засаг даргын 2018 оны
 02 дугаар сарын 22 ны өдрийн 4/42 дугаар
 захирамжийн хавсралт



УЛСЫН НӨӨЦИЙН ЦЭГҮҮДЭЭС СУМДАД
 ҮНЭГҮЙ ОЛГОХ ӨВС, 50 ХУВИЙН ХЯМДРАЛТАЙ
 ОЛГОХ ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Олгох улсын нөөцийн цэгийн байршил	Хүлээж авах сум	Өвсний тоо хэмжээ	Тэжээлийн тоо хэмжээ
			Тонн	Тонн
1	Аймгийн төв дэх нөөцийн салбар 252 тн өвс, 100 тн хивэг, 50 тн хорголжин	Халиун	30	20
2		Тонхил	8	10
3		Жаргалан	30	20
4		Тайшир	30	20
5		Есөнбулаг	34	30
6		Дэлгэр	30	20
7		Шарга	30	10
8		Дарви	30	10
9		Хөхморьт	30	10
10	Баян-Уул сум дахь нөөцийн цэг 30 тн өвс, 30 тн хивэг	Баян-Уул	30	20
11		Хөхморьт	-	10
12	Төгрөг сумын Борбулаг дахь нөөцийн цэг 48 тн өвс, 50 тн хивэг	Төгрөг	20	10
13		Цээл	20	10
14		Дарви	-	10
15		Алтай	-	10
16		Бугат	8	10
17	Эрдэнэ сум дахь нөөцийн цэг 40 тн өвс, 50 тн хивэг	Дэлгэр	8	10
18		Чандмань	8	10
19		Цогт	8	10
20		Эрдэнэ	8	10
21		Бигэр	8	10
	НИЙТ ДҮН		370	280



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 4/48

Алтай хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Билгийн тооллын XVII жарны "Нөхөрсөг" хэмээгч шар нохой жилийн сар шинийн баярын аймгийн нэгдсэн золголт зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, "Уул уурхай, Барилга байгууламж-2018" форум зохион байгуулах ажлын хэсгийг хоёр, гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн нэгдсэн золголт, "Уул уурхай, Барилга байгууламж-2018" форумын арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж, өндөр түвшинд зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.


3. Дээрх арга хэмжээг улс, орон нутагт сурталчилах, таниулах ажлыг үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Алтайбаатар/, Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 02 ны өдрийн 1/48 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**САР ШИНИЙН БАЯРЫН АЙМГИЙН НЭГДСЭН ЗОЛГОЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга: Ч.Бат-Эрдэнэ -аймгийн Засаг даргын Тамгын газрын
дарга

Дэд дарга: Б.Алтайбаатар -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга

Гишүүд: М.Эрдэнэбилэг -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ц.Буянжаргал -Цэргийн штабын дарга, хурандаа

Б.Баян-Эрдэнэ -Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Н.Энхбат -Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга

Д.Ганзориг -Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга

Ц.Эрдэнэбаяр -Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга

Б.Ундрах -Нэгдсэн эмнэлгийн дарга

Б.Шинэбаяр -"Нийтлэг үйлчилгээ" ОНТҮГ-ын дарга

Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Н.Бямбацогт -Биений тамир, спортын газрын дарга

С.Болормаа -Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн
газрын дарга

Аймгийн Засаг даргын 2018. оны
02 дугаар сарын 08 ны өдрийн 8/18 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



**"БАРИЛГА БАЙГУУЛАМЖ-2018" ФОРУМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: В.Рэнцэндорж -аймгийн Засаг даргын орлогч

Дэд дарга: Ч.Бат-Эрдэнэ -аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: С.Байгальмаа -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого

төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

П.Баасан -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын

хэлтсийн дарга

Р.Батмөнх -Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Ш.Ган-Эрдэнэ -Онцгой байдлын газрын дарга

З.Мөнхнасан -Орон нутгийн өмчийн газрын дарга

Ц.Туяа -Эрүүл мэндийн газрын дарга

Г.Ариунболд -Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга

Г.Чүлтэмжамц -Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Х.Амартүвшин -Гаалийн албаны дарга

Нарийн бичгийн дарга: М.Ууган-Эрдэнэ -Газрын харилцаа, барилга, хот

байгуулалтын газрын дарга

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 2 ны өдрийн 1/28 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**"УУЛ УУРХАЙ-2018" ФОРУМ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Ж.Ганбат -аймгийн Засаг даргын орлогч

Дэд дарга: А.Мөнхтөр -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн
бичгийн дарга

Гишүүд: Ч.Жаргалсайхан -Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Баттайван -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Түмэнбаатар -Мэргэжлийн хяналтын газрын дарга

М.Мянганбуу -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

З.Мөнхнасан -Орон нутгийн өмчийн газрын дарга

Г.Түмэннасан -Цагдаагийн газрын дарга

Б.Тунгалаг -Статистикийн хэлтсийн дарга

Н.Энхтуяа -Татварын хэлтсийн дарга

Л.Энхжаргал -Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Л.Мөнх-Эрдэнэ -Говь-Алтай аймгийн "АЗЗА" ТӨХК-ий захирал

Нарийн бичгийн дарга: Д.Батмагнай -Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/49

Алтай хот

Сар шинийн баярын өдрүүдэд урьдчилан
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баярын үеэр аймгийн цахилгаан, дулаан, усан хангамж, сумдын болон онцгой объектуудын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах аймгийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, жижүүрийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймаг, сумдын удирдлага, ард иргэдэд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээллийг тогтмол хүргэж, болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын удирдлагыг мэргэжлийн удирдлагааар хангаж, үүрэгжүүлж ажиллахыг Онцгой байдлын газар /Ш.Ган-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Сар шинийн баярын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийг амгалан тайван байх нөхцөлийг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар /Г.Түмэннасан/-т даалгасугай.

4. Аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих эргүүл, жижүүрийг томилон ажиллуулж, Онцгой байдлын газрын 7048105, 7048101 дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг өдөр бүрийн 10.00, 20.00 цагуудад, яаралтай мэдээ, мэдээллийг тухай бүр нь өгч ажиллахыг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын удирдлага, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын 2016 оны А/382 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралтад заасан хуваарийн дагуу хариуцсан сумдтайгаа байнгын холбоотой байж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өдөр бүрийн жижүүрт мэдэгдэж байхыг Онцгой комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2018 оны 02 дугаар сарын 19-нд танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Б.Баттайван/, Онцгой байдлын газар /Ш.Ган-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНСЭЛЭМ



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

02 00149

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 02 ны өдрийн 4/49 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН
АЖИЛЛАХ ХУВААРЬ

Он сар өдөр	Ерөнхий жижүүрийн нэрс	Албан тушаал	Жижүүрийн хуваарь
02 сарын 16	Д.Баттайван	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	09.00-09.00
	Г.Баасан-Очир	Тагнуулын хэлтсийн дарга	
	Г.Түмэннасан	Цагдаагийн газрын дарга	
	П.Баасан	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга	
02 сарын 17	Л.Мөнх-Эрдэнэ	АЗЗА ТӨХК-ий захирал	09.00-09.00
	Ц.Эрдэнэбаяр	Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын дарга	
	Ч.Жаргалсайхан	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	
	Ш.Ган-Эрдэнэ	Онцгой байдлын газрын дарга	
02 сарын 18	С.Гантулга	Автотээврийн төвийн дарга дарга	09.00-09.00
	Ш.Дагва	Есөнбулаг сумын Засаг дарга	
	Ц.Буянжаргал	Цэргийн штабын дарга	
	Б.Алтайбаатар	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 02 ны өдрийн 4/49 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ЕРӨНХИЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ А0042

1. Аймгийн ерөнхий жижүүр цаашид ерөнхий жижүүр гэх нь Онцгой байдлын газар дээр төвлөрч 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.
2. Ерөнхий жижүүрүүд үүрэг гүйцэтгэсэн хугацаандаа дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж дараагийн эргүүлд дараагийн өдрийн 09.00 цагт ажлаа албан ёсоор хүлээлгэн өгнө.
3. Улсын онц чухал объект, үйлчилгээний байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж тухайн байгууллагын дарга нартай байнгын холбоотой байж, шаардлагатай бол шуурхай зөвлөгөөн хийж болно.
4. Эргүүлээр ажиллах хугацаанд гэмт хэргийн шинж чанартай асуудал илэрвэл цагдаагийн байгууллагад шуурхай мэдэгдэж зохих арга хэмжээ авна.
5. Аймгийн ерөнхий жижүүр нь аймгийн Засаг дарга, түүний орлогч, Онцгой байдлын газрын дарга, Есөнбулаг сумын Засаг даргад тогтмол мэдээлэл өгч үүрэг чиглэл авч ажиллана.
6. Аймгийн төвийн байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлагатай эргүүл жижүүрийг ерөнхий удирдлагаар хангаж, үүрэг чиглэл өгнө.
7. Ажлын шаардлагаар холбогдох байгууллагын даргад мэдэгдэн мэргэжлийн хүн, хүчийг дайчлан ажиллуулж болно.
8. Ерөнхий жижүүрийн ажиллах хугацааны унаа, шатахууны зардлыг тухайн байгууллагаас хариуцна.
9. Иргэдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг Онцгой байдлын газрын 7048105 дугаарын утсаар тухай бүр нь мэдэгдэнэ, ирсэн мэдээлэл, дуудлагын мөрөөр шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллана.
10. Байгууллага аж ахуйн нэгжүүд ерөнхий жижүүрийн шаардсан мэдээг цаг хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.
11. Томилгоот жижүүрүүд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, захирамжийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд хариуцлага тооцно.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 4/50

Алтай хот

Цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 6.1 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4, 8.7 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдын 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд улс, бүс, аймгийн наадамд үзүүлсэн амжилтаараа “Аймгийн алдарт уяач” цолны болзол хангасан уяачдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. “Аймгийн алдарт уяач” цолны болзол хангасан уяачдад Цагаан сарын баяраар цолны үнэмлэх, энгэрийн тэмдэгийг олгосугай.

3. Аймгийн Үндэсний их баяр, бүсийн наадамд өндөр амжилт үзүүлсэн “Аймгийн алдарт уяач”-дыг амжилтаар нь эрэмбэлж эхний 5 уяачдыг “Аймгийн шилдэг уяач”-аар шалгаруулж шагнасугай.

4. Шагналд зарцуулагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

5. Аймгийн “Уяач тэмээчин” цолоор Эрдэнэ сумын тэмээчин Ц.Болдсайхан, М.Ууган-Эрдэнэ, Алтай сумын тэмээчин Б.Мэндсайхан нарыг шалгаруулсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, баяр наадмын комиссын дарга /Ж.Ганбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны
 02 дугаар сарын 09 ны өдрийн А/50 дугаар
 захирамжийн хавсралт



“АЙМГИЙН АЛДАРТ УЯАЧ”-ИЙН БОЛЗОЛ
 ХАНГАСАН УЯАЧДЫН НЭРС

№	Уяачдын овог нэр	Үндсэн захиргаа
1	Намжилын Давааням	Шарга сум
2	Бүдрагчаагийн Батхуяг	Шарга сум
3	Тожилжавын Алтанхуяг	Халиун сум
4	Дамдины Дашдондов	Халиун сум
5	Нороогийн Энхтөр	Халиун сум
6	Чадраагийн Батбаатар	Халиун сум
7	Шатарбалын Энхбаатар	Халиун сум
8	Төмөрбатын Мөнгэрэл	Халиун сум
9	Чойжилжавын Болд	Бигэр сум
10	Мөнхийн Баттулга	Бигэр сум
11	Бүдширийн Галсанпирэнлэй	Цогт сум
12	Цэрэгдоржийн Дарьбазар	Цогт сум
13	Дүнгэрийн Майдаржав	Цээл сум
14	Лхажавын Гэсэрболд	Дэлгэр сум
15	Цээпилийн Наранбаяр	Дэлгэр сум
16	Жүгдэрийн Баттөр	Тонхил сум
17	Лантуугийн Отгонбаяр	Тонхил сум
18	Хасбаатарын Алтангэрэл	Тонхил сум
19	Бузанковын Эрдэнэсүрэн	Тонхил сум
20	Өлзийбатын Бямбадорж	Тонхил сум
21	Жамъяншаравын Лоохууз	Тонхил сум
22	Авирмэдийн Дашдорж	Есөнбулаг сум
23	Батбаясгалангийн Хоролсүрэн	Есөнбулаг сум
24	Гончигсүмийн Лхагвадорж	Есөнбулаг сум
25	Дамдинбазарын Бат-Оргих	Жаргалан сум
26	Ганбатын Даваацэрэн	Жаргалан сум
26	Мягмарын Баясгалан	Жаргалан сум
27	Дэндэвийн Буянхишиг	Чандмань сум
28	Жамганы Самбуу	Чандмань сум
29	Дүгэрцэндийн Энхбат	Чандмань сум
30	Дарийн Аварзэд	Хөхморьт сум
31	Энхтуяагийн Гансүх	Хөхморьт сум
32	Пүрэвдоржийн Тэрбиш	Хөхморьт сум
33	Алагийн Нэргүй	Төгрөг сум
34	Ногооны Төмөр	Бугат сум
35	Хулганы Түндэв	Бугат сум
36	Жигмэдийн Дэмбэрэлсайхан	Эрдэнэ сум
37	Гаадсүрэнгийн Ариунболд	Эрдэнэ сум
38	Цогзолын Наранбаатар	Эрдэнэ сум
39	Халзангийн Өсөхбаяр	Тайшир сум
40	Дондовын Баттогтох	Тайшир сум
41	Батцэрэнгийн Нэргүй	Тайшир сум
42	Намсрайн Цэрэндаш	Тайшир сум
43	Хоохоны Отгонбаяр	Цээл сум
44	Хүрэлбаатарын Заяабаатар	Цээл сум



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 1/51

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотын нэгдсэн халаалтын 2-р зуухны доголдлыг арилгаж, хэвийн үйл ажиллагаанд оруулахаар Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооны мэргэжилтнүүд, Налайхын дулааны станц, Дулааны 3-р цахилгаан станцын засварчдаас бүрдсэн ажлын хэсэг болон Алтай хотод байгуулагдах дулааны станцын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах Бүгд Найрамдах Солонгос Улсын KDHEC компанийн төлөөлөгчид, Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төвийн мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг тус аймагт ажиллахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Зарцуулагдах 2655720 /Хоёр сая зургаан зуун тавин таван мянга долоон зуун хорин/ төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /М.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Алтайбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 08 ны өдрийн 1/5/ дугаар
захирамжийн хавсралт



НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН АЖЛЫН ХЭСЭГ АЙМАГТ
АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

№	Гаргах зардал	Хүний тоо	Тоо хэмжээ	Нийт үнэ /төгрөг/
1	Буудал	8	5 хоног	1100000
2	Хоол	8	5 удаа	410720
	Нийт			1510720

ХОЁРДУГААР ЭЭЛЖИЙН АЖЛЫН ХЭСЭГ АЙМАГТ
АЖИЛЛАХАД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

№	Гаргах зардал	Хүний тоо	Тоо хэмжээ	Нийт үнэ /төгрөг/
1	Буудал	10	3 хоног	825000
2	Хоол	10	3 удаа	320000
	Нийт			1145000

__оОо__



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 1/52

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт харьяалагдах улсын чанартай авто замын тэмдэг, тэмдэглэлд үзлэг шалгалт хийж, нарийвчилсан судалгаа гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Ганбат -аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Э.Золзаяа -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Батбаатар -Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга

Б.Бөхбаяр -Замын цагдаагийн тасгийн зохицуулагч

Нарийн бичгийн дарга: С.Дугарсүрэн -"ГА-А33А" ТӨХК-ний ерөнхий инженер

2. Ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллан дүнг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ж.Ганбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/54

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII жарны "Тийн унжлагат" нөхөрсөг хэмээх шар нохой жилийн "Цагаан сарын баяр"-т зориулсан хүчит бөхийн барилдааны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 797000 /Долоон зуун ерэн долоон мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /М.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /М.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны
02... дугаар сарын 14-ны өдрийн А/Б/ дугаар
захирамжийн хавсралт



БӨХЧҮҮДИЙН БАЙ ШАГНАЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Бөхийн даваа	Бөхийн тоо	Нэг бөхийн шагнал	Нийт
1	Нэг давсан	16	5000	80000
2	Хоёр давсан	8	10000	80000
3	Гурав давсан	4	30000	120000
4	Шөвгөрсөн	2	40000	80000
5	Үзүүрлэсэн	1	70000	70000
6	Түрүүлсэн	1	100000	100000
7	Медаль	4ш	5000	20000
8	Өргөмжлөл	4ш	8000	32000
9	Тавгийн идээ	1ш	65000	65000
Дүн				647000

**БАРИЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Үүрэг гүйцэтгэсэн	Ажилласан хүний тоо	Нэг хүнд олгох ажлын хөлс	Нийт
1	Гарын даа	1	10000	10000
2	Хөлийн цэц	1	10000	10000
3	Засуул	8	10000	80000
4	Эмч	1	10000	10000
5	Идээ тараагч	1	10000	10000
6	Бай олгогч	1	10000	10000
7	Тайлбарлагч	1	20000	20000
Дүн				150000

__ооо__



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 7/55

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 37 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Улсын хошой аварга малчин”-аар шалгарсан Дарви сумын Хужирт багийн малчин Осорхүүгийн Гансүх, “Улсын аварга малчин”-аар шалгарсан Халиун сумын Чацран багийн малчин Цагааны Мөнхбат, Тонхил сумын Бүс-Уул багийн малчин Чантуугийн Бузанков, Жаргалан сумын Бүрэн багийн малчин Самбуугийн Пүрэвсүрэн, Дарви сумын 2 дугаар багийн малчин Бүдрагчаагийн Дашцэрэн, Чандмань сумын Эрдэнэ-Уул багийн малчин Налжирын Намжилсүрэн, Дэлгэр сумын Баянбуурал багийн малчин Тулгачийн Алзахгүйбаатар, Шарга сумын Хамтын хүч багийн малчин Банзарын Дашмягмар, Төгрөг сумын 4 дүгээр багийн малчин Дашдоржийн Даваахүү, “Улсын аварга тариаланч”-аар шалгарсан Халиун сумын тариаланч Мамаагийн Хайдав болон тэдний гэр бүлийн хүмүүст хүндэтгэл үзүүлэх, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн нэрэмжит “Алтан төлийн эзэд”-д шагнал гардуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах зардал 5596080 /таван сая таван зуун ерэн зургаан мянга наян/ төгрөгийг Засаг даргын бэлтгэл хөрөнгөнөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /С.Байгальмаа/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 14 ны өдрийн АЗС дугаар
захирамжийн хавсралт

УЛСЫН АВАРГУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХЭД
ӨГСӨН ОЛГОСОН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бэлэг /Мөнгөн аяга, бичээс, хадаг самар, чихэр, дээлийн өнгө,жааз/	иж бүрэн	10	240160	2401600
2	Аваргуудад олгох гэрийн тээврийн хөлс	ширхэг	10	140000	1400000
3	Бренд бүтээгдхүүний танилцуулга /MNB-д/	иж бүрдэл	1	36500	36500
4	00-01ГАА, 00-03 ГАА шатахуун/ Жаргалан, Тайшир, Дэлгэр, Чандмань, Халиун, Төгрөг, Тонхил, Дарив, Шарга, Цээл, Хөхморьт, Баян-Уул сумдад	литр	390	1790	554900
		литр	168	1810	304080
		литр	220	2150	473000
5	"Алтан төлийн эзэд"-ийн бэлэг дурсгалын зүйл	ширхэг	6	77080	462500
ДҮН					5596080

"АЛТАН ТӨЛИЙН ЭЗЭД"-ИЙН НЭРС

Д/д	Сумын нэр	Шагнагдсан иргэдийн нэрс	Шагналын нэр
1	Цээл	Алзахгүйбаатар	Алтан ишиг
2	Цээл	Түмэнжаргал	Алтан ишиг
3	Цээл	Нацагдорж	Алтан шишг
4	Дарив	Батбилэг	Алтан хурга
5	Дэлгэр	Лхажив	Алтан ботго
6	Тайшир	Ч. Нямбуу	Алтан унага



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 18 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/56

Алтай хот

Газар эзэмших эрх сэргээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2017 оны A/447 дугаар захирамжаар газар эзэмших эрх нь цуцлагдсан "Аксу-Алтай" ХХК-ий гэрээгээр хүлээсэн үүргийн зөрчлөө арилгасан тул уг нэгж талбар газрыг эзэмших эрхийг сэргээн эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу уг нэгж талбарыг эзэмшигч "Аксу-Алтай" ХХК-тай байгуулсан газар эзэмших гэрээ болон газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчинтэйд тооцсугай.

3. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны A/447 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/57

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ази фарм" ХХК-ий салбар эмийн сан ажиллуулах, "Ариусгал Алтай" ХХК-ий Ахуйн шавьж устгах, халдваргүйжүүлэлт хийхэд тусгай зөвшөөрлийг тус тус гурван жилээр олгосугай.

2. "Энхийн зуун" дотор мэдрэлийн эмнэлэг, "Амгалан Энх" хүүхэд, уламжлалтын үүдэн эмнэлэг, "Алтай тан" ХХК-ий "Алтай тан" эмийн сан, "Аминдэм-Алтай" эмийн санг ажиллуулах тусгай зөвшөөрлийг тус тус гурван жилээр сунгасугай.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс /М.Эрдэнэбилэг/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/, Эрүүл мэндийн газар /Ц.Туяа/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 9/58

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.8, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг “Цогт интернэйшнл” ХХК-аар гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ч.Бат-Эрдэнэ/-т олгосугай.

2. Ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах, тайланг хүлээн авч, танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /П.Баасан/-т үүрэг болгосугай.

3. Хэрэглэгчийн үнэлгээнд шаардагдах 8500000 /найман сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гарган зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

4. Хэрэглэгчийн үнэлгээний тайланг баталгаажуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ч.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

02. 00173



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/59

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиаргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалт, "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 172 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө, хандиваар уран барималч Б.Говьсайханы урласан Монголын утга зохиолын нэрт төлөөлөгч, төр, нийгмийн зүтгэлтэн Чадраабалын Лодойдамбын хүрэл хөшөө, зохиолчийн төрсөн газрын буурийг тохижуулах ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Байгальмаа -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч дарга

Гишүүдэд: А.Мөнхтөр -Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Ч.Жаргалсайхан -Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

М.Эрдэнэбилэг -Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

М.Мандаххүү -Архивын тасгийн дарга

Х.Чилаажав -Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн удирдах зөвлөлийн гишүүн

Р.Пүрэвдорж -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Шуубанза -Хоёрдугаар сургуулийн захирал

Б.Нармандах -Тайшир сумын Соёлын төвийн эрхлэгч

Ж.Дашдаваа -"Шадар туслагч" ХХК-ий гүйцэтгэх захирал

Нарийн бичгийн дарга:Б.Бямбадорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, аймгийн ерөнхий архитектор

2. Тус ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч үр дүнг танилцуулахыг комисс /С.Байгальмаа/-т үүрэг болгосугай.

3. Хөшөөний цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Хоёрдугаар сургуулийн захирал /Д.Шуубанза/-д, Тайшир сумын Соёлын төвийн эрхлэгч /Б.Нармандах/-д, Соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, хамгаалалтад авахыг Орон нутаг судлах музей /Ц.Оюунзуул/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНСЭЛЭМ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

02.00178



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20/8 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/01

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын XVII жарны "Нөхөрсөг" хэмээгч шар нохой жилийн сар шинийн нийтээр тэмдэглэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Нийтээр тэмдэглэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах 644600 /Зургаан зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ

Аймгийн Засаг даргын 2018 оны
02 дугаар сарын 20 ны өдрийн А/Б/ дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

ДЮА0042

№	Материалын нэрс	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт
1	Хавсаа	110	1500	165000
2	Чихэр	5	18000	90000
3	Самар	3	10000	30000
4	Еэвэн	1	10000	10000
5	Гүүний айраг	15	7000	105000
6	Жижиг чихэр	3	12000	36000
7	Мандал өргөх ёслолд	1	150000	150000
	Дүн			586000
	Татвар 10%			58600
	Нийт дүн			644600

__оОо__



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 1/62

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 71 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх аймгийн Мэргэжлийн хяналтын газарт фургон автомашин нийлүүлэх ГААОНӨГ/201801010 дугаартай ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Түмэнбаатар/-т үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ч.Жаргалсайхан/, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Алтайбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНСЭЛЭМ